

# АУДИТ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА 2024

## АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын захидал .....	3-р хуудас
Тусгай зөвшөөрөл .....	4-р хуудас
Хараат бус байдал .....	4-р хуудас
Үйл ажиллагааны танилцуулга .....	5-р хуудас
Аудит, зөвлөх үйлчилгээний танилцуулга .....	6-р хуудас
Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний танилцуулга ....	7-р хуудас
Бидний туршлага .....	8-р хуудас
Аудитын багийн танилцуулга .....	9-р хуудас





## С.МӨНХБАЯР

### ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Мэргэшсэн Нягтлан Бодогч  
Татварын Мэргэшсэн Зөвлөх  
Аудитор

### Эрхэм ХҮНДЭТ ХАРИЛЦАГЧ ТАНД

Юуны өмнө бидэнтэй аудит, зөвлөх үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллахаар сонирхож, компанийнхаа үйл ажиллагааг танилцуулах боломж олгож байгаад талархал илэрхийлье.

Бид 2007 оноос хойш санхүүгийн үйлчилгээний салбарт шинэ өнгө төрх, шинэ технологи бий болгон ажиллаж байна. Манай хамт олонд Мэргэжлийн болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан бодогч, Татварын Итгэмжлэгдсэн Нягтлан бодогч, Аудитор, Үнэлгээчин, Программ хангамжийн инженер, Санхүүгийн багш гэх мэт зэрэг цолтой, дэвшилтэт технологи эзэмшсэн 35-40 орчим бүтээлч залуус ажиллаж байна.

Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн аудитын үйлчилгээг сонгох 5 шалтгаан:

№	Товч	Тайлбар
1.	ТОП-20	Бид-Монгол улсын ТОП-20 аудитын компанийн нэгээр сүүлийн 6 жил тасралтгүй шалгарсан.
2.	Онцлох аудитын компани	“Аудитын программыг амжилттай хөгжүүлж аудиторуд төдийгүй аудитын үйлчлүүлэгчдэд өгөх үнэ цэнийг нэмэгдүүлсэн” тул ММНБИ-ээс 2022 оны Онцлох аудитын компаниар шалгаруулсан.
3.	Шилдэг ТМЗ компани	Татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалах, эрсдлийг бууруулах чиглэлээр хийсэн ажил, гаргасан ололтуудыг үнэлэн Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгээс 2024 оны Шилдэг ТМЗ компаниар шалгаруулсан.
4.	Мэдлэгийн сан	Бид-Байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тулгардаг эрсдэл бүхий асуудлуудаар Мэдлэгийн сан үүсгэн ажиллаж байгаа бөгөөд харилцагч бүрийн санхүү болон НББ-ийн үйл ажиллагаанд тохирсон аудитын зөвлөмжийг хурдан хугацаанд, чанартай хийж гүйцэтгэхийг зорьдог.
5.	Аудитын программ	Бид-Мэжикийн аудитын горимыг үр ашигтай, богино хугацаанд хэрэгжүүлэх зорилгоор өөрсдийн хөгжүүлсэн программ хангамжийг ашигладаг.
6.	Үйл ажиллагааны автоматжуулалт	Аудитын үйл ажиллагаанд мэдээллийн аюулгүй байдал, алдаагүй шуурхай үйлчилгээний нөхцлийг бүрдүүлж Microsoft эко системд процессийн автоматжуулалтыг аудитын бүх шатанд хөгжүүлэн нэвтрүүлж ашигладаг.

Аудит, зөвлөх үйлчилгээний ажлыг бид зөвхөн танай байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан Аудитын Олон Улсын Стандартын дагуу мэргэжлийн ёс зүйг баримталж, чанартай гүйцэтгэнэ гэдэгтээ итгэлтэй байна.

Бидэнтэй аудит, зөвлөх үйлчилгээний үнийн санал, аудитын багийн гишүүдийн сонголт болон хараат бус байдал, үйлчилгээний талаар санал солилцоход таатай байх болно.



## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Мэжик Консалтинг Аудит ХХК нь Сангийн яам, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт болон Санхүүгийн зохицуулах хорооноос доорх тусгай зөвшөөрлүүдийг аван ажиллаж байна.

Огноо	Тусгай зөвшөөрлийн нэр	Олгосон байгууллага
2007	Санхүү, НББ-ийн сургалт явуулах	Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт
2010	Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	Сангийн яам
2014	Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	Сангийн яам
2016	Үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагад аудит хийх эрхийн гэрчилгээ	Санхүүгийн зохицуулах хороо
2016	Даатгалын байгууллагад аудит хийх эрхийн гэрчилгээ	Санхүүгийн зохицуулах хороо

## ХАРААТ БУС БАЙДАЛ

Мэжик Консалтинг Аудит ХХК нь Аудитын Олон Улсын Стандарт (АОУС), Чанарын Хяналтын Олон Улсын Стандарт (ЧХОУС), Монгол Улсын Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д тодорхойлсны дагуу танай байгууллагаас хараат бус гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Мэжик Консалтинг Аудит ХХК нь танай байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй бөгөөд аудитын багийн гишүүд нь хараат бус байдалд нөлөөлөх харилцаа холбоо байхгүй болно. Хэрэв бид танай компанитай аудитын үйлчилгээний гэрээ байгуулах үед багийн гишүүдэд хараат бус байдалд нөлөөлөх харилцаа холбоо байгааг мэдсэн тохиолдолд албан бичгээр мэдэгдэл хүргүүлнэ.

Мэжик Консалтинг Аудит ХХК нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-нд хөдөлмөрийн гэрээ байгуулах болон ажилтныг шинээр ажилд орох үед ажилчдын ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл авч урьдчилан сэргийлж ажилладаг.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Манай компани аудит, нягтлан бодох бүртгэлийн залгамж халааг бэлтгэх, чадвартай мэргэжилтэн бий болгох зорилгоор 2014 оноос хойш Нягтлан бодох бүртгэлийн улсын олимпиадын ивээн тэтгэгчээр жил бүр оролцож байна.





## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Мэжик Консалтинг Аудит ХХК нь аудит баталгаажуулах, татварын мэргэшсэн зөвлөх, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх, аутсорсинг, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж, НББ-ийн сургалтын үйлчилгээг 2007 оноос хойш үзүүлж байна.

Бид Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад 3 салбар оффист 40 орчим мэргэжилтэнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Хамт олны дэлгэрэнгүй танилцуулгыг [www.magicgroup.mn/mn/team](http://www.magicgroup.mn/mn/team) цахим хуудаснаас харна уу.

Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтээс жил бүр аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компаниудын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг нэгтгэн эрэмбэлдэг бөгөөд бид 2016 оноос хойш Монгол улсын ТОП 20 аудитын компанийн нэгээр тасралтгүй шалгарч байна.

### ҮНДЭСНИЙ АУДИТЫН КОМПАНИАР ЖАГСААВАЛ

1-р байр

1-р байр

1-р байр

4-р байр

2-р байр

1-р байр

6-р байр

2016

2017

2018

2019

2020

2021

2022

### ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН АУДИТЫН КОМПАНИАР ЖАГСААВАЛ

6-р байр

7-р байр

8-р байр

13-р байр

11-р байр

10-р байр

16-р байр



## АУДИТ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

### Санхүүгийн тайлангийн аудит

Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд толилуулсан мэдээлэл нь үнэн зөв эсэхэд эргэлзэж буй хөрөнгө оруулагч, сонирхогч этгээдүүд болон санхүүгийн мэдээлэл хэрэглэгчдэд тухайн тоон мэдээ үнэн зөв гэдэг эцсийн баталгааг гаргаж ажиллах явдал юм.

Санхүүгийн тайланд дүгнэлт, баталгааг өгөх байгууллага, багийн ур чадвар, мэргэжилтний сонголтыг зөв хийснээр өөрийн хүлээлт, түүнээс давсан үр дүнг харж цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад тань үндэс суурь болно.

### Зөвлөх үйлчилгээ

Таны эрхэлж буй бизнес нь өөрчлөлт, шинэчлэлт эсвэл одоогийн нөхцөл байдлыг улам бататгаж ажиллахад тохиромжтой зөвлөгөөг авч хэрэгжүүлж ажиллах эсэхээс ихээхэн хамаарч байдаг. Таны бизнесийн үйл ажиллагаанд шинээр гарсан болон шинэчлэгдэн өөрчлөгдөж буй Санхүүгийн тайлагналын стандарт, хууль, дүрэм журмууд зэрэг нь шууд болон шууд бусаар давуу болоод сул талуудыг авчирч байдаг.

Бизнес нөлөөлж буй давуу ба сул талуудыг хэрхэн оновчтойгоор ашиглахыг манай зөвлөх үйлчилгээний мэргэшсэн баг, хамт олон өөрсдийн практикт тулгарсан асуудал, түүнээс олж авсан туршлагадаа үндэслэн танд зөвлөх болно.

## ГАДААД ХАРИЛЦАА

### Бид дэлхийн гурав дахь том НББ-ийн нийгэмлэгийн гишүүн байгууллага



Мэжик Консалтинг Аудит ХХК нь 2023 оны 12 сард PrimeGlobal Нягтлан бодох бүртгэлийн нийгэмлэгийн гишүүн боллоо.

Олон улсын нягтлан бодох бүртгэлийн эмхтгэл (IAB) дэлхийн нягтлан бодох бүртгэлийн сүлжээ, нийгэмлэгүүдийг оролцуулан жил бүр судалгаа гаргадаг бөгөөд PrimeGlobal нь дэлхийн гурав дахь том нийгэмлэгийн жагсаалтанд орсон.

PrimeGlobal нь бие даасан 300 гаруй гишүүн пүүсүүдээс бүрдсэн дэлхийн 112 орны 1000 гаруй байршилд 3400 гаруй түнш гишүүн пүүсүүдэд нийт 34000 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа нягтлан бодох бүртгэлийн нийгэмлэг юм.

Бид PrimeGlobal нийгэмлэгийн гишүүн болсноор доорх давуу талууд бий болж байгаа юм.

- Гишүүн байгууллагууд нь хаана ч байсан дэлхийн шилдэг туршлага, мэдлэгээс суралцах боломжтой
- Үйлчлүүлэгчдэд өндөр түвшний үйлчилгээ үзүүлэхэд PrimeGlobal-аас мэргэжлийн туслалцаа авах боломжтой.
- Компанийн өсөлт, хөгжил, санхүүгийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой.



## ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Бизнесийн байгууллагуудын хувьд ирээдүйд учирч болох хамгийн том эрсдэлүүдийн нэг нь татвар, нийгмийн даатгалын эрсдэл билээ. Иймд:

- Татвар, нийгмийн даатгалын тайлан гаргах, тайланд хяналт тавих;
- Дотоод аудит хийх;
- Үйлчлүүлэгчийг татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлөөлөх;

зэрэг асуудлуудыг багтаасан цогц үйлчилгээг манай мэргэжлийн хамт олон санал болгож байна.

### Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 3.1.1-д зааснаар “Үйлчлүүлэгчийн татвар төлөх үүргээ биелүүлэх, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн мэргэшсэн зөвлөх үйл ажиллагааг Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ гэнэ.

Уг үйлчилгээг авснаар үйлчлүүлэгч нь татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг тухайн хуулийн этгээдээс шаардах эрхтэй байдаг. Бид дараах үйлчилгээг үзүүлж байна:

- Татварын тайлан тооцоо, тохируулга хийх, тайлан бэлтгэх;
- Байгууллагын санхүү, татварын тайлагналын хяналт зөвлөгөө;
- Татвар болон нийгмийн даатгалын шалгалтад бэлдэх, эрсдэлийг үнэлэх;
- Татвар төлөгчдийг төлөөлж татвар, нийгмийн даатгал болон санхүү төрийн сангийн хэлтсүүдтэй хамтарч ажиллах;
- Татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйлчлүүлэгчдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх хууль зүйн зөвлөгөө өгөх;

### Нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг үйлчилгээ

Аж ахуй нэгж байгууллагууд санхүүгийн бүртгэлээ нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн хувь хүн, компанид хариуцуулж ажиллуулахыг Аутсорсинг үйлчилгээ гэнэ. Бид дараах үйлчилгээг үзүүлж байна:

- Санхүү, татварын тайлан гаргах;
- Гаргасан тайлангуудад цахимаар баталгаажуулалт хийх;
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу зөвлөгөө өгөх;
- Анхан шатны баримт материалыг стандартын дагуу үдэж цэгцлэх;

### Үйлчилгээний давуу тал

Харилцагчдын татварын хяналт шалгалтаар акт, торгууль тавигдах эрсдэлийг бууруулж ажилладаг.

1. Санхүү, татварын программ хангамжтай бөгөөд уг программыг гэрээний хугацаанд ашиглуулдаг.
2. Үйл ажиллагаагаа явуулах дотоод стандарт, хяналтын системтэй.
3. Харилцагчидтай жил бүр бизнес уулзалт зохион байгуулж, хийсэн ажлаа тайлагнадаг.
4. Өөрсдийн туршлагадаа тулгуурлан Мэдлэгийн сан хөгжүүлэн ажилладаг бөгөөд харилцагчид тулгамдаж буй асуудал болон учирч болзошгүй эрсдэлд зөвлөмж, зөвлөгөө өгч ажилладаг.
5. Харилцагч нарынхаа санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулдаг.

## БИДНИЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ - МАНАЙ НЭРИЙН ХУУДАС

Өнгөрсөн хугацаанд биднийг сонгон үйлчлүүлсэн үйлчлүүлэгчид бол бидний өнөөдрийн амжилтын үндэс суурь юм. Манай аудит баталгаажуулах үйлчилгээг гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагууд, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагууд, уул уурхайн компаниуд, төрийн болон орон нутгийн өмчит хувьцаат компаниуд, эрүүл мэнд, боловсролын байгууллагууд, төрийн бус байгууллагууд авсан байна.





**Манай харилцагчдаас дурдвал:**

**ТӨРИЙН ӨМЧИТ  
КОМПАНИУД**

- Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК
- Цахилгаан Дамжуулах Сүлжээ ХХК
- Монгол Шуудан ХК
- Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
- Эрдэнэс Оюу Толгой ХХК
- Шингэн Түлш Шилжүүлэн Ачих Байгууламж ТӨҮГ
- Алтай Улиастай Эрчим Хүчний Систем
- Зээлийн Батлан Даалтын Сан
- Бөртэ Улсын Үйлдвэрийн Газар
- Улсын Драмын Эрдмийн Театр
- Монголын Үндэсний Музей
- Монголын Театрын Музей
- Гоц Халдварт Өвчин Судлалын Газар

**ДОТООДЫН БИЗНЕСИЙН  
БАЙГУУЛЛАГУУД**

- MCS групп түүний охинкомпаниуд
- Монголын Ипотекийн Корпораци ХК
- ЛэндМН ББСБ ХК
- Нэйшнл Лайф Даатгал ХХК
- Улаанбаатар Смарт Карт ХХК
- Улаанбаатар Телевиз ХХК
- Ньюс Ремикон ХХК
- Номадс Катеринг энд Сэрвис ХХК
- Азийн Зам ХХК
- Анд-Энерги ХК
- Апекс Софт ХХК
- Монложистик тракинг ХХК

**ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ  
АЖ АХУЙН НЭГЖҮҮД**

- Рэдпаф Монгол ХХК
- ЖАЙКА Дээд Боловсролын Төсөл
- Мэрри Стопс Интернэйшнл
- Плэйлэнд ХХК
- ДонБоско Олон Улсын МСҮТ
- Пиртек Монгол ХХК
- ТМХС ХХК
- Шин Ён Стийл ХХК
- Азиа Галф Сервис Төлөөлөгчийн Газар

**ТӨРИЙН БУС  
БАЙГУУЛЛАГУУД**

- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрлэлийн Танхим
- Өдрийн Сонин
- Монголын Үнэт Цаас Арилжаа Эрхлэгчдийн Холбоо ТББ
- Монгол Ви И Ти Нет ТББ
- Ханган Нийлүүлэгчдийн Хөгжил, Чанарын Төв
- Засагт Хан Дээд Сургууль
- Залуучуудын Нөхөрлөл ТББ
- Цогт Цагийн Хүрдэн Соёлын ТББ
- Норвегийн тусламжийн байгууллага



ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙГ  
МОНГОЛД



MONGOLIAN MORTGAGE CORPORATION  
МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ



ӨНДӨР ХУРДЫН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ



МОНГОЛ  
ШУУДАН



Mining Contractors  
and Engineers



Улаанбаатар  
Смарт Карт



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА  
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ



ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ



ЗЭЭЛИЙН БАТЛАН  
ДААЛТЫН САН



МонголФарм



МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН  
ХОЛБОО  
ӨВЧИЙГӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛАГА



МОНГОЛЫН  
ҮНДЭСНИЙ МУЗЕЙ



ASHUUIS



National Life



AND ENERGY



MARIE STOPES  
INTERNATIONAL  
MONGOLIA



"ЭЗИН ЗАН" ХХК



NEWSPAPERS DAILY  
DN



PLATINUM LAND LLC




## АУДИТЫН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Мэжик Консалтинг Аудит ХХК нь Аудитор, Зөвлөх үйлчилгээний мэргэжилтнүүддээ дараах боломжийг олгон ажиллаж байна.


- Өсөн дэвших тэгш боломж
- Хийж бүтээх таатай орчин, урам зориг
- Зах зээлийн үнэлгээнд тохирсон цалин урамшуулал
- Шинэ үеийн чадварлаг нэг баг болон хамтран ажиллах

Багийн гишүүдийн зэрэг цол эзэмшсэн байдал нийт ажилчдын хувьд:



Санхүүгийн тайлангийн аудитын багийг Партнер удирдаж, менежерүүд хяналтыг хэрэгжүүлж ажиллах бөгөөд холбоо барих хаягийг танилцуулгад байршуулсан болно.

АУДИТЫН БАГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ  
ДАРААХ БАЙДАЛТАЙ БАЙНА:







**С.МӨНХБАЯР**  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

*Мэргэшсэн Нягтлан Бодогч  
Татварын Мэргэшсэн Зөвлөх*



**Д.ТҮМЭНЖАРГАЛ**  
ПАРТНЕР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч*



**Ч.АЛТАНГЭРЭЛ**  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч*



**Н.МӨНХЗАЯА**  
АУДИТЫН МЕНЕЖЕР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч*



**Х.АЛТАНЗАЯА**  
ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч*



**Г.ОЮУН**  
АХЛАХ АУДИТОР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч*



**Д.БАТЦЭЦЭГ**  
АХЛАХ АУДИТОР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч  
Татварын Мэргэшсэн Зөвлөх*



**Н.МАНДАХ**  
АУДИТОР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч*



**Д.НАРАНБАТ**  
АУДИТОР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч*



**Х.АМГАЛАНЗАЯ**  
ТМЗ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч  
Татварын Мэргэшсэн Зөвлөх*



**Б.МӨНХТУЯА**  
НЯГТЛАН БОДОГЧ

*Татварын Мэргэшсэн Зөвлөх*



**В.ЦЭЛМҮҮН**  
АУДИТОР



**Г.БЯМБАЦЭЦЭГ**  
НЯГТЛАН БОДОГЧ

*Мэргэшсэн Нягтлан Бодогч  
Татварын Мэргэшсэн Зөвлөх*



**Б.ДАНЗАНДОРЖ**  
ТУСЛАХ АУДИТОР



**Г.ЯНЖИНСҮРЭН**  
ТУСЛАХ АУДИТОР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч  
Татварын Мэргэшсэн Зөвлөх*



**О.БАЯРТ**  
ТУСЛАХ АУДИТОР

*Мэргэшсэн Нягтлан Бодогч*



**А.ЖАМЪЯАН**  
ТУСЛАХ АУДИТОР



**В.АНГАР**  
ТУСЛАХ АУДИТОР

*Татварын Мэргэшсэн Зөвлөх*



## МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Хэмжиж үл чадвал, Удирдаж үл чадна

### ХОЛБОО БАРИХ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
43-р хороо, UB tower, 15-р давхар, 1502 тоот

**АУДИТ БАТАЛГААЖУУЛАХ  
ҮЙЛЧИЛГЭЭ:** 7288-7288, [audit@magicgroup.mn](mailto:audit@magicgroup.mn)  
8811-2064

**ТАТВАРЫН МЭРГЭШСЭН  
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ:** 7288-7288, [tax@magicgroup.mn](mailto:tax@magicgroup.mn)  
8811-0975

